

ТЭНГЭРЛИГ ЭРДЭМТЭН ВАН ГОВЭЙ

Д.Наран*

Ван Говэй 1877 онд төрж багаасаа эцэг болон багшаараа хятадын уламжлалт “Дөрвөн ном, таван бичиг” хэмээх сонгодог зохиолыг чамгүй сайн заалгасны эцэст бие даан сурах арга барилтай болжээ. Тэрбээр 16 насандаа бичгийн эрдмийн сюцай цол амжилттай хамгаалав. Тэр үед хятадын нийгмийн дотор радикал шинэчлэл хийхийг шаардсан хөдөлгөөн өрнөж, зарим сэхээтнүүд эвсэлдэн нэгдэж Чин улсын хууль тогтоомжуудыг өөрчлөн шинэчлэхийг шаардах болов. 22 настай Ван Говэй Шанхай хотноо хүрэлцэн ирж “Ши Ү Бао” (монголоор бол “Цаг үе, үйл явдал”) сонинг эрхлэн гаргахад хүчин зүтгэж Ло Жэньюийн байгуулсан Дорно дахины утга зохиолын нийгэмлэгийн дэргэдэх гадаад хэлний дамжаанд элсч япон, англи хэл сурчээ. Бяньфа буюу 1895 оны хууль цааз шинэчлэх төлөө хөдөлгөөнийг манжийн эрх баригчид нухчин дарсны улмаас “Ши Ү Бао” сонин хаагдаж, Ван Говэй Дорно дахины утга зохиолын нийгэмлэгтээ өдөр тутмын бага сага ажил хийнгээ япон багш нарынхаа нөлөөгөөр барууны гүн ухаантан И.Кантын бүтээлийг судлах болов. Удалгүй Ло Жэньюгийн хамт Учаны Хөдөө аж ахуйн сургууль, Шанхайн Наньяны сургуулийн Хункоу дахь салбар, Тунжоугийн Багшийн их сургууль, Сужоугийн Багшийн сургуульд гүн ухаан, сэтгэл судлал, ёс зүй, нийгэм судлалын хичээл заахын хамт “Нун Бао” (Хөдөө нутгийн сонин), “Зяоюй Бао” (“Боловсрол сонин”) сонины редакцид ажиллаад Японы Токио хотод очиж

Физикийн ухааны сургуульд бас суралцжээ. Ван Говэй 28 насандаа “Улаан асарын зүүд романы шүүмж”, 29 насандаа гүн ухаан, ёс зүй, сэтгэл зүй, боловсрол судлал, утга зохиолын холбогдолтой шинэлэг асуудал дэвшүүлсэн бүтээлүүд туурвисан нь тухайн үедээ олны анхаарлыг ихэд татсан юм. 31 насандаа Бээжинд ирж суув. Энэ үед хятад хэлний гарваль үүсэл, хятад жүжгийн түүхийг судалсны үндсэн дээр “Хүмүүний үг хэл”, “Сун, Юаны үеийн ший жүжгийн түүх” бүтээлээ туурвилаа.

1915 онд “Түүхэн тэмдэглэл”, “Ханьшу” гэх эртний нангиадын түүхийн сурвалж бичгийн мэдээ баримт, “Түүхэн тэмдэглэл” ба “Жаогийнхны удам судар” хэмээх бичигт манай он тооллоос өмнө 305 оны үеийн умартын нүүдэлчин үндэстний хувцасны талаар бичсэн тэмдэглэлийг иш үндэс болгон “Ху нарын хувцас” (Ху гэж умартын нүүдэлчин аймгуудыг нангиадын сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг) гэх бүтээлээ бичив. Одоогоос 2300 жилийн тэртээ Жао Улинь гэгч ван хэргэмтэн хань үндэстний хувцасны уламжлалт хэв загварыг өөрчилж шинэ хэв маяг нэвтрүүлсэн ажээ. Ван Говэй ху нарын хувцсыг биеийн дээд ба доод гэж үндсэн хоёр хэсэгт хуваах, мөн малгай, бүс, гутал зэргийг нэмж оруулах санал дэвшүүлжээ. Хятадын эртний Байлдаант улсын үеийн ханлиг улсуудад ху нарын хувцасны хэв загварыг ихэд дуурайх болжээ. Зүүн Хань улсын сүүл үеэр гарсан тасралтгүй дайн дажныг дагаад ху нарын хувцас нангиад хүмүүсийн дунд өргөн

* Д.Наран. МУИС-ийн ГХСС-ийн захирал, доктор (Ph.D) профессор

дэлгэрэв. Вэй, Зинь улс мөхсөний дараа жирийн хүмүүс, түшмэд бүр байтугай эзэн хаан нь хүртэл ху маягийн хувцсаар гангардаг болсон байна. Бас нэг давуу тал гэвэл ху нарын хувцас аян дайны нөхцөлд хамгийн их тохиромжтой байлаа. Эртний Хятадын умарт хэсэгт төр улсаа байгуулж байсан нүүдэлчин үндэстний хувцасны дэгжин гоё хэв маягт татагдсан нангиад охид бүсгүйчүүд түүгээр гангарах дуртай болов. Умарт Вэй улсад ху нарын жирийн өдөр тутмын хувцас тун их дэлгэрчээ. Дараа нь эртний нангиад хувцсаа сэргээн хэрэглэсэн боловч ху маягийн хувцас бүрэн халагдсангүй. Хятадын Суй улсын эзэн хаан, цэргийн жанжингууд дайн байлдаан хийхдээ ху маягийн хувцас өмссөөр байлаа. Тан улсын үед Суй улсын хувцас маяг үндсэндээ өөрчлөгдсөнгүй. Сунгийн үед ху маягийн хувцас дундад орноор өргөн түгээмэл дэлгэрсээр байсан тухай Ван Говэй уг бүтээлдээ бичжээ.

Ван Говэй судалгааны ажилдаа урьд өмнө эрдэмтдийн хөндөж байгаагүй эх сурвалжуудын мэдээг ашиглаж тэдгээрт тайлбар хийсэн юм. Гэтэл энэ нүсэр, хэн хүний хийхээргүй ажлыг гагцхүү эртний бичгийн хятад хэлний өндөр мэдлэгтэй хүн хийж чадахаар байлаа. Ван Говэй энэхүү хийж гүйцэтгэсэн ажил дараа дараагийн судлаачдад Монголын түүх, тэр тусмаа Юаны түүхийн талаар судалгаа хийх замыг нь тавьж бэлэн хэрэглэхүүн, материалуудыг буй болгон өгчээ. Ван Говэй 1913 оноос Монголын түүх, Юан гүрний түүхийн судалгаа хийж эхлэв. 1925-1927 оны хооронд ердөө хоёрхон жилд нижгээд түүхэн эх сурвалжуудын учир утгыг тайлж тайлбар хийж өгчээ. Түүний эл хугацаанд хийж амжуулсан ажлаас дурьдвал “Yuanchao Mishi” (Монголын нууц товчоо) нийт 12 дэвтэр бүхий хоёр боть, “Yuanmi Shizhu” (МНТ-ны тайлбар), “Huang Yuan Shengu Qinzhen Lu” (Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл), “Menggu Yuanliu” (Монголчуудын гарваль үүсэл), “Yuanshi

Yiwen Zhengbu” (Юанши-ийн орчуулгад оруулах нэмэлт), “Meng Wuer Shiji” (Монголчуудын түүхэн тэмдэглэл), “Menggu Youmuji” (Монголын нүүдэлчдийн тухай тэмдэглэл), “Yuanchao Mingchen Shiji” (Юаны нэрт түшмэдийн үйл хэргийн товчоо), “Xiyoulu” (Баруун зүгийн тэмдэглэл), “Helin Jinshilu” (Хар Хорины Алтан хөшөөний бичиг) зэргийг оруулж болно. Ван Говэй биечлэн Монголын Юан гүрний түүхтэй холбогдох 22 сурвалж бичгийг эмхэтгэн тайлбар зүүлт хийснээс заримыг энд дурьдахад

1. Чанчунь бомбын баруун газар зорчсон тэмдэглэл
2. Монгол татарын бүрэн тэмдэглэл
3. Хар татарын хэргийн тэмдэглэл
4. Умарын түүх
5. Барууны түүх
6. Ван Тиндэгийн Гаоча-ын тухай тэмдэглэл зэрэг нь хожмын эрдэмтэн судлаачдын ажлыг маш их хялбарчилж өгсөн билээ.

Ван Говэй монголын дунд эртний түүх судлахдаа Юаны үеийн дуу хөгжмийг ихэд анхаарч сонирхсон юм. Энэхүү дур сонирхол нь түүний судалгааны амжилтын гол хөшүүрэг нь болж өгчээ. Юаны дуу хөгжмийн талаар арваад бүтээл туурвижээ.

“Татарын судалгаа” нь Ван Говэй монгол үндэстний эртний түүхэн судалгааны гол бүтээл болно. Татар гэх нэр Тан улсын Сюань Зун хааны кайюаний 20-р он буюу 732 онд босгосон Культегиний чулуун хөшөөний түрэг бичээст анх тэмдэглэгдсэн болохыг уг бүтээлдээ өгүүлжээ. “Татарын судалгаа” бүтээлийн ард “Татарын он дарааллын бичиг”-ийг зүүлт болгон хийж түүндээ Тангийн Сяньтунгийн 9-р оноос буюу 868 оноос Алтан улсын Тайхэгийн 4-р он буюу 1204 он хүртэл 300 гаруй жилийн турш монгол хэлтэн шивээ аймгаар гол цөмөө бүрдүүлсэн татарын түүхийг он цагтай нь хамт сурвалж бичгүүдийн материалыг нэгтгэн тун тодорхой өгүүлсэн байна.

Ван Говэй 1925 оны 12-р сард “Монголын тухай судалгаа” бүтээлээ бичиж дуусгав. Анх “Ляо Алтан улсын үеийн Монголын тухай судалгаа” нэртэй байсан уг зохиолдоо өмнөд Сун улсын хүмүүсийн Монголын тухай бичиж үлдээсэн баялаг баримтуудыг нэмж дахин найруулж 1927 оны 5-р сард “Монголын тухай судалгаа” нэртэй хэвлүүлжээ. Тэр нь Чингис хаан 1206 онд Монгол улс байгуулахаас өмнөх түүхэн үйл явдлуудыг судалсан чухал бүтээл болно. Ван Говэй амьдралынхаа хугацаанд 60 гаруй бүтээл туурвижээ.

Ван Говэй ид туурвиж байсан цаг үе бол хятадын нийгэм, дотоод байдал туйлын ээдрээтэй, дайн байлдаантай цаг байлаа. Чан Кайшийн үндэсний армийн умарын аян дайн амжилттай өрнөж, Бээжин дэх умартын засгийн газар гүн хямралд орж, хятадын нийгэм түм түжигнэж бум бужигнасан цаг

үе байлаа. Ван Говэй улс орныхоо хувь заяа, ирээдүйн төлөө сэтгэл зовнин явсаар тэр нь түүний сэтгэл санаанд нөлөөлсөн үү, 1927 оны 6-р сарын 2-ны өдөр 51 насандаа Бээжингийн Куньмин нуур луу үсэрч амиа егүүтгэжээ. Түүний эл явдлыг харсан хүмүүс араас нь орж уснаас гаргасан авч эмнэлгийн яаралтай тусламж үзүүлж чадаагүй учир түүний оюунлиг бие нь хорвоог орхин одсон байна. Эдүгээ хятадын ард түмэн, сэхээтэн, эрдэмтэд Ван Говэй хэмээх онгод билгээ нийгэмдээ зориулсан тэнгэрлиг их эрдэмтэн багш хүний дурсгалыг хүндэтгэн түүний дурсгалыг хүндэтгэн жил бүр эрдэм номын олон арга хэмжээ зохиодог бөгөөд түүний монголын түүхийн талаар хийсэн арвин их судалгааны ажлууд монголчууд бидний бахархал хүндэтгэлийг зүй ёсоор хүлээж явдаг билээ.